



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Төрийн удирдлага

Индекс: D041303

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Эрдэнэсүрэн

Гишүүд: Н.Бурмаа
Г.Энхбаяр

2020.06.08

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- БУХС - Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
- БСШУЯ – Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яам
- БМИҮЗ –Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Төрийн удирдлага	
Индекс	D041303	
	Багийн ахлагч: 1. Б.Эрдэнэсүрэн МХИДС-ийн холбооны ерөнхийлөгч Багийн гишүүд: 1. Н.Бурмаа МУИС-ийн профессор 2. Г.Энхбаяр Удирдлагын академийн багш	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	05/20	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	05/27	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	05/29	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	06/02, 03	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	06/10	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/10	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	06/11	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/12	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны А/66 тушаал.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

“Төрийн удирдлага” хөтөлбөр нь анх ТИС-ийн Эрдмийн Зөвлөлийн 1998 оны 10 сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрээр “Төрийн захиргааны менежмент” (D340200) нэртэйгээр батлагдаж, 1998 оноос сургалт явуулж эхэлсэн бөгөөд 2002 онд анхны төгсөлт хийсэн.

1998–2001 онд КтМС–ийн Үйлдвэрлэлийн технологийн тэнхим

2002–2007 онд Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын профессорын баг

2007-2014 онд Менежментийн профессорын баг


2014 оноос одоог хүртэл БУХС-ийн Нийгмийн ухаан салбарт харьяалагдах болсон.

“Төрийн захиргааны менежмент” мэргэжил нь 2014-2017 онд БСШУ-ны Сайдын 2014 оны 03 сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаалаар “Нийтийн удирдлага” хөтөлбөр, 2017 оноос БСШУС-ын Сайдын 2017 оны 06 сарын 29-ний өдрийн А/52 тоот тушаалаар “Төрийн удирдлага (D041303)” хөтөлбөр болж өөрчлөгдөн сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн 20 жилийн хугацаанд “Төрийн удирдлага” мэргэжлийн хөтөлбөрөөр нийт 236 бакалавр, 114 магистр төгсгөсөн бөгөөд одоо тус хөтөлбөрт 78 бакалавр оюутан, 106 магистрант, 5 докторант суралцаж байна.

“Төрийн удирдлага” хөтөлбөрөөр бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр нь БМИҮЗ-ийн 2014 оны 09 сарын 09-ний өдрийн 01 тогтоолоор 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэгдсэн.

Хөтөлбөрийн зорилго: Нийтийн төлөөх бодлого, онол, арга зүйн мэдлэг; нийтийн алба, нийтийн ажил үйлчилгээний практик ур чадвар; өргөн хүрээний мэдлэг бүхий дээд боловсролтой иргэн бэлтгэхэд оршино.



III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Төрийн удирдлага хөтөлбөр 2014 болон 2016 онд өөрчлөгдсөн байна. Шинжээчдийн баг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2016 оны 6 сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн “Нийтийн удирдлага” хөтөлбөрийн бакалаврын сургалтын төлөвлөгөөнд магадлан итгэмжлэх үйл ажиллагаа хийсэн болно.

Тус хөтөлбөрийн бүтцийг харуулбал:

- Ерөнхий суурийн хичээл 36 кр
 Үүнээс: заавал судлах 30 кр
 сонгон судлах 6 кр
- Мэргэжлийн суурь хичээл 33 кр
- Мэргэжлийн хичээл 41 кр
- Дадлага 6 кр
- Бакалаврын төгсөлтийн ажил 5 кр
- Танилцах болон мэргэжлийн дадлага 6 кр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бакалаврын төгсөлтийн ажил 5 кр, танилцах болон мэргэжлийн дадлага 6 кр байна.

Анхаарах асуудал:

- Ерөнхий суурийн сонгон судлах хичээлүүдийн хувьд нийт сонголт хийх хичээл 13 байгаагаас оюутан зөвхөн 2 хичээлийн нийт 6 кр сонгох боломжтой.

Зөвлөмж:

- Ерөнхий суурийн сонгон судлах хичээлийн сонголтын тоог 10 хүртэл бууруулбал оюутан хичээл сонголт хийхэд хялбар бөгөөд оновчтой байх боломжтой.
- Хөтөлбөрийг Art-ыг тодорхой болгох.
- Бакалаврын төгсөлтийн ажил бичих кр 5 байна. Бусад их дээд сургуулийн жишгээр бакалаврын төгсөлтийн ажлын кр-ийг 3 болговол оюутан энэ хөтөлбөрөөр шинээр 1 хичээлийг судалж мэдлэгээ өргөтгөх боломжтой.
- Танилцах болон мэргэжлийн дадлагыг нэгтгэн үйлдвэрлэлийн дадлага болгон 3-4 кр болгон өөрчилбөл оюутанд судлах мэргэжлийн хичээл нэмэгдэж мэдлэгээ өргөтгөх боломжтой.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилгын хүрээнд мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Тус хөтөлбөрийн дадлага 6кр, мөн төгсөлтийн ажил 5 кр байгаа нь оюутныг бие дааж ажиллах, судалгаа хийх, мөн практик дадлагад суурилсан ажиглагдаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн онцлогийг менежментэд суурилсан хэмээн тайлбарлаж байгаа боловч үүнийг хөтөлбөрөөс төдийлөн олж үзээгүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн онцлогийг менежментэд суурилсан хэмээн тайлбарлаж байгаа боловч үүнийг хөтөлбөртөө мэдэгдэхүйц онцлон тусгах.
- Төрийн удирдлагын эргүүлэх хөтөлбөр бүхий гадаад улс орнуудын их дээд төрийн удирдлагын хөтөлбөрт заагдаж буй туршлагаас суралцах, харьцуулсан судалгаа хийж хэвших

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлүүдийн багц материал бэлтгэгдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- 2016 онд боловсруулсан хөтөлбөрт дахин өөрчлөлт хийх төлөвлөгөө гаргасан.

Анхаарах асуудал:

- ШУТИС-ийн Хөтөлбөрийн хороод, хөтөлбөр батлах үйл явц шатлалын хувьд хэт төвлөрсөн нь хөтөлбөрт өөрчлөлт оруулахад хүндрэл учруулдаг.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой үйл ажилагааг аль болох олон шат дамжлагагүй уян хатан болгох.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутан хичээл сонгосон тохиолдолд оюутны тооноос үл хамааран тухайн хичээлийг шууд судлах боломжтой. Тухайлбал тухайн хичээлийг сонгох оюутны тооны хамгийн бага хязгаар байхгүй. /1-2 оюутан хичээл сонгосон ч судлах боломж нээлттэй/.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн хичээлүүд уялдаа холбоотой.

Анхаарах асуудал:

- Хичээлүүдийн судлах болон нэмж судлах ном зүйд англи болон бусад гадаад хэл дээр ном сурах бичиг цөөн байна.

Зөвлөмж:

- Хичээлүүдийн судлах болон нэмж судлах ном зүйд англи болон бусад гадаад хэл дээрх нэмэлт эх үүсвэрүүдийг тусгах.
- Англи болон бусад гадаад хэл дээр хэвлэгдсэн ном сурах бичигтэй болох.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтыг CDIO арга зүйн аргачлалаар зохион байгуулдаг. Сургалтын орчин тоног төхөөрөмж, хичээл заах арга зүйд нийцсэн. Цахим болон бусад арга зүйгээр хичээл заагддаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- CDIO сургалтын заах арга зүй нэвтэрсэн

Анхаарах асуудал:

- Багш нар салбарын түвшинд үйл ажиллагаагаа ихэвчлэн зохион байгуулдгаас Төрийн удирдлага хөтөлбөрийн онцлог асуудлын талаар тэр бүр нарийн хөнддөггүй. Хөтөлбөрийн багш нар Төрийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн семинар болон мэргэжлийн чиглэлээр ярилцлага хийн харилцан туршлагаа дотооддоо солилцдог тал дээр анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн багш нар Төрийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн семинар болон мэргэжлийн чиглэлээр ярилцлага хийн харилцан туршлагаа хөтөлбөрийн

дотооддоо солилцдог байвал үр дүнтэй. Мэргэжлийн семинар болон мэргэжлийн чиглэлээр ярилцлага хийн харилцан туршлагаа дотооддоо солилцдог тал дээр анхаарах.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны улирлын болон явцын шалгалтын дүн
- Суралцагчтай хийсэн цахим ярилцлага
- Төгсөгчидтэй хийсэн цахим ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа

Анхаарах асуудал:

- Асуудлыг салбарын түвшинд хэлэлцдэг тул Төрийн удирдлага хөтөлбөрийн түвшинд нарийвчлан авч үзэхэд хүндрэлтэй.

Зөвлөмж:

- Төрийн удирдлага хөтөлбөрийн түвшинд нарийвчлан авч үзэж байх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Тус сургууль нь олон жил сургалт явуулж ирсэн, үйл ажиллагаа нь тогтворжсон. Хичээлийн байрандаа урсгал засвар тогтмол хийж хэвшсэн. Байрны ариун цэвэр, өнгө үзэмж сургалт явуулах шаардлагад бүрэн нийцэж байна. 2017 онд сантехникийн капитал засвар хийснээр байрны дулаан хангамж сайжирсан. Анги, танхимыг засварлах ажил сүүлийн жилүүдэд сайн хийгджээ. Хичээлийн анги, танхимууд проектор болон сургалтын бусад техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон. 2019 онд “Төрийн удирдлага” хөтөлбөрийн ангийг шинээр тохижуулснаар магадлан итгэмжлэгдэж байгаа хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл зохих хэмжээгээр сайжирсан. Оюутны байрны нэг блокод 6 оюутан амьдардаг бөгөөд блок бүр нь тусдаа ариун цэврийн өрөө, шүршүүртэй. Байранд амьдрах нөхцөл сайн. Сургуулийн бүтэц, зохион байгуулалтад гарсан өөрчлөлттэй холбоотойгоор хичээлийн байрны ашигтай талбай 200м.кв, үүнээс сургалтын талбай 400м.кв, суудлын тоо 190-ээр, нийт өрөө 13-аар тус тус буурчээ. \Хүснэгт1\.

Хүснэгт 1 Хичээлийн байрны хангамж, өөрчлөлт

	Норм	2015-2016	2018- 2019	Өөрчлөлт
Хичээлийн байрны ашигтай талбай	м.кв	8064	7864	-200
Үүнээс сургалтын талбай	м.кв	2600	2200	-400
Суудлын тоо		910	720	-190

Нийт өрөөний тоо		99	86	-13
Лабораторийн өрөө		7	4	-3
Номын фондын өрөө		2	2	-
Уншлагын танхим	250- 300м.кв	288м.кв	288м.кв	-
Хичээлийн анги, танхим		21	17	-4
Нэг оюутанд ногдох сургалтын талбай	2,0м.кв	2,8м.кв	2,5м.кв	-0,3
Хичээлийн өрөөний нэг суудалд ногдох талбай	2,2- 2,5м.кв	2,4м.кв	2,3м.кв	
Ээлж ашиглалтын коэффициент	1,6	1,2	1,2	-
Нэг багшид ногдох конторын талбай	4м.кв	3м.кв	3м.кв	-
Оюутны байрны нэг оршин суугчид ногдох талбай	4м.кв	5м.кв	5м.кв	

Энэ өөрчлөлт уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар нөлөө үзүүлснийг тодрууллаа. Барилгын норм ба дүрмийн сургалт, хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжтай холбоотой заалтуудыг үндэслэн нэг оюутанд ногдох сургалтын талбай 0,5м.кв-аар, оюутны байрны нэг оюутанд ногдох талбай 1м.кв-аар илүү, ээлж ашиглалтын коэффициент болон уншлагын танхимын хэмжээ, хичээлийн өрөөний нэг суудалд ногдох талбай тус тус хэвийн байна.

Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр оюутнуудаас жил бүр 14 асуулт бүхий асуулга авдаг. Судалгаанд хамрагдсан 835 оюутаны 63% нь орчин нөхцөл хангагдсан гэж үзжээ.

Сургалтын тоног төхөөрөмжийн хангамж шаардлага хангаж байна гэж үзлээ. Лабораторийн компьютеруудын 60% нь i5,40 % нь i3- аас бүрдэж байна.Төрийн удирдлага хөтөлбөрийн багш нар нийт 8 суурин, 6 зөөврийн компьютер, 8 принтер, 2 проектор, 3 скайнер ашигладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуулийн дэргэдэх Нийгмийн ажлын нээлттэй мэдээлийн төв нь нийгмийн чиглэлээр ажилладаг судлаачид, оюутан, мэргэжлийн байгууллага, олон нийтэд дэмжлэг үзүүлдэг.
- Сургуулийн дэргэдэх “Гурван хэмжээст мэдээлэл зүй, дизайны лаборатори, эмнэлэг зэрэг нь орчин үеийн хэрэгслээр тоноглогдсон бөгөөд сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж, дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Анхаарах асуудал:

- Өнгөрсөн хичээлийн жилийн эцэст авсан 806 оюутны санал асуулгаас үзэхэд интернетийн хурд тааруу, ашиглах боломж хязгаарлагдмал гэж судалгаанд хамрагдагсдын бараг хагас нь хариулсныг анхаарах.
- Сургалт, хүмүүжлийн байгууллагын барилгын нормын 66-88-ын 3,38- 3,40 дэх заалтын дагуу эдэлбэр газрын 30%-аас багагүй хэсгийг ногоон болгох заалт хангалтгүй биелэгдэж байна.

Зөвлөмж:

- Интернетийн хурдыг сайжруулж, ашиглах бололцоог нэмэгдүүлэх.
- Сургуулийн гадаад орчинг илүү үзэмжтэй болгож, ойжуулах, цэцэрлэгжүүлэх асуудалд анхаарах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Тухайн хичээлийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг сайжруулах ажлыг тогтмол хийдэг. 2014 оноос хойш сургалтын төлөвлөгөөг 2 удаа шинэчилж, хичээлийн давхардлыг арилгах,

хөтөлбөрийн агуулгыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авсан. Хөтөлбөрийг шинэчлэх, дадлага хичээлийн чанарыг сайжруулах чиглэлээр профессорын семинарыг тогтмол зохион байгуулдаг. Салбарын дэргэдэх заах арга зүйн зөвлөлөөр сургалтын аргыг боловсронгуй болгох, сургалтын хэрэглэгдэхүүний өгөөж, чанарыг сайжруулах ажил тогтмол хийгддэг. Энэхүү зөвлөл санаачлан сургалтын кэйсийн сан бүрдүүлжээ. Сургалтын ажлыг зохион байгуулах дүрэм, журам, захирлын зөвлөлийн шийдвэр, тушаал, заавруудыг вэб сайтад байршуулжээ. ШУТИС-ийн хэмжээнд Сургалтын кредит систем ба удирдлагын мэдээллийн Cloud UNIMIS, цахим сургалтын UNIMIS, MOODLE, удирдлага, хяналт шинжилгээний MIS систем ашиглагдаж, хэвшсэн. Багш бүр цахим хуудсаа ашиглан хичээлийн хуваарь, тухайн хичээлийг сонгон судалж байгаа оюутны нэрс, дүнгийн хуудас зэргийг ил тод хөтөлдөг. Энэ хичээлийн жилийн сүүлийн хагаст сургалт онлайн хэлбэрээр явагдаж байгаатай холбоотойгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх хэрэглэгдэхүүнийг онлайн хэлбэрт оруулж боловсруулжээ. Тус сургуульд ашиглагдаж байгаа цахим цэс нь тухайн хичээлийг судалдаг оюутны нэрс, код, утас, багшийн хичээлтэй танилцсан эсэх, бие даалтын ажлын удирдамж, тухайн хичээлийн лекц, семинар, бусад шаардагдах материалууд болон санал асуулгын хэсгүүдтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагааны UNUMIS программ хангамжийн V.3 шинэчилсэн хувилбар хийгдэж, бүх түвшний оюутан хичээлийг онлайнаар сонгон суралцах боломж бүрджээ.
- Хөтөлбөрийн оролцогч талууд өөрийн хэрэгцээт мэдээллээ хүссэн үедээ мэдээллийн нэг цэгээс авч ашиглах боломж бүрдсэн.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн номын сан 230 суудалтай, 3 уншлагын танхимтай. Эрдэм шинжилгээ- Е уншлагын танхимтай. Оюутны байранд номын сантай. Долоо хоногийн 6 өдөрт 5 номын санч, 2 ээлжээр ажилладаг. Түүнчлэн ШУТИС-ийн төв номын санг оюутнууд чөлөөтэй ашиглах бололцоотой. Нийт багш, оюутны дунд хэрэгцээт номын судалгаа явуулах замаар номын сангийн фондыг баяжуулдаг. Сүүлийн 5 жилийн номын фондын баяжилтын 29,5%-ийг Төрийн удирдлага хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах ном, сурах бичиг, гарын авлага эзэлж байгаа талаар тайланд дурдсан боловч хичээл тус бүрээр ном, сурах бичгийн хангамж ямар байгаа талаарх мэдээлэл алга байна. Харин мэргэжлийн хичээлийн ном, сурах бичгийн ач холбогдол, хэрэгцээг нь харгалзан тоо, ширхгийг нь нэмэгдүүлэх шаардлагатай нь санал асуулгаас харагдаж байна. Өнгөрсөн онд Төрийн удирдлагын мэргэжлийн сурах бичгийг боловсруулж, хэвлэсэн нь уг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нэг чухал нөхцөл болжээ. Мэргэжлийн сэтгүүл, хэвлэлийг тогтмол захиалан ашигладаг. Номын сангийн үйл ажиллагааг сайжруулах талаар жил бүр оюутны санал асуулга явуулдаг. Төрийн удирдлага хөтөлбөрийн 51 оюутны асуулгын дүнгээс үзэхэд ном, сурах бичгийн хүрэлцээ хангалттай биш гэж хариулжээ. Номын сан үйлчилгээндээ е-каталог, е-ном, е-сэтгүүл, онлайн мэдээллийн сангуудыг ашигладаг.
- Төрийн удирдлага хөтөлбөрийн мэрэгшүүлэх хичээлүүдийн ном, сурах бичгийн хангамжтай тусгайлан танилцлаа. Мэргэжлийн суурь болон заавал судлах хичээлүүдэд нийт 305 төрлийн 1000 гаруй ном, сурах бичиг ашиглагдаж байна. Тэдгээрийн 74,9%-ийг монгол, 15%-ийг англи, 10,1%-ийг орос хэл дээрх материал эзэлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Номын сангийн үйлчилгээний чанарыг сайжруулах.
- Сурах бичгийн эрэлт, хэрэгцээг судлах замаар тоо, ширхгийг нь оновчтой тогтоох замаар хүртээмжийг сайжруулах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр болон салбар хариуцсан профессорууд, багш нартай хийсэн ярилцлага
- Төгсөгчидтэй хийсэн цахим ярилцлага
- Ажил олгогчтой хийсэн цахим ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн сургалтад өөрчлөлт оруулахад ШУТИС-ийн олон шат дамжлага нь асуудлыг шийдвэрлэхэд удаашралтай.

Зөвлөмж:

- ШУТИС-ийн дотоод зохион байгуулалт, хөтөлбөрийн хороодын үйл ажиллагааг анхаарах.
- Салбар дотооддоо хөтөлбөрийн үйл ажиллагааг нарийвчлан авч үздэг байх.
- Салбар хоорондын хөтөлбөрийн уялдааг анхаарах.
- Хөтөлбөрийн удирдлага бие дааж шийдвэрлэх, үйл ажиллагааг ШУТИС-ийн бодлогын түвшинд дэмжих.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамтын ажиллагаатай байгууллагын гэрээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БНСУ-н ЧУСО-н их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд Төрийн удирдлагын оюутнуудыг БНСУ-д дадлага хийх боломжтой болсон. Өнгөрсөн хугацаанд 4 оюутан дадлага хийсэн байна. Төрийн удирдлага хөтөлбөрийн оюутнуудын зүгээс зөвхөн нислэгийн тийзээ хувиасаа төлөх ба бусад зардлыг БНСУ-ын тал хариуцдаг.

Анхаарах асуудал:

- Хамтын ажиллагааны хувьд хийгдэж буй гэрээнүүд ихэвчлэн салбарын түвшинд хийгддэг тул Төрийн удирдлага хөтөлбөрийн онцлогт зориулан хийсэн тусгайлсан гэрээ байхгүй.

Зөвлөмж:

- Төрийн удирдлага хөтөлбөрийн ач холбогдлыг өсгөх, багш оюутнуудыг идэвхжүүлэх үүднээс зөвхөн салбарын түвшинд бус, хөтөлбөрийн түвшинд хийвэл тус хөтөлбөрийн ач холбогдол илүү үр дүнтэй болно.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн 2017-2019 санхүүгийн тайлан
- Салбарын санхүүгийн зарцуулалтын тайлан 2017-2019

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ШУТИС-ийн түвшинд нэгтгэгдсэн.

Анхаарах асуудал:

- Салбарын болон хөтөлбөрийн зарцуулалтыг зардлын зүйл ангиар ялган шинжилгээ хийхэд учир дутагдалтай.

Зөвлөмж:

- Санхүүгийн төлөвлөгөөг хөтөлбөрийн түвшинд зардлын зүйл ангиар нарийвчлан төлөвлөж байх.
- Санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан шинжилгээ хийж байх.
- Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээ хийж занших.
- Зарцуулалтын зүйл ангид Төрийн удирдлагын мэргэжлийн ном сурах бичиг / гадаад хэл дээр/ худалдан авалтыг төлөвлөж байх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нартай хийсэн ярилцлага
- Ерөнхий боловсролын сургуулиудад хөтөлбөрийн сурталчилгаа хийдэг

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ЕБС дээр удаа шат дараатай төлөвлөгөөтэй очиж хөтөлбөрөө сурталчилдаг.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн сурталчилгаанд багш нарыг ажиллуулахаас гадна тус хөтөлбөрөөр суралцаж буй оюутан, төгсөгч нарыг оролцуулбал илүү үр дүнтэй.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Ажил олгогчтой хийсэн цахим ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургуулийн веб сайтад хөтөлбөрийн танилцуулгыг оруулах.
- Бусад их дээд сургуулиудтай хамтран хөтөлбөрийн чанарыг сайжруулалт харилцан туршлагаа солилцож хэвших

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлт нь МУ-ын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан БСШУСЯ-ны “Оюутан элсүүлэх” журам, ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам зэрэг хууль, журмын дагуу зохицуулагдаж байна.
- Элсэгчдийн дундаж оноо 521, элсэлтийн хувь сүүлийн хичээлийн жилд 85% болж өмнөх оноос буурчээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Математик, гадаад хэл суурилсан элсэлтийн ерөнхий шалгалтын 480 оноогоор оюутан элсүүлдэг нь ШУТИС-ийн хүрээнд оюутны сигментийг тодорхойлдог юм байна.
- 4 жилээр төгсгөдөг боловч 3.5 жилээр төгсөх боломжийг оюутанд бүрдүүлж өгсөн байна.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоо цөөрөх хандлагатай байна.

Зөвлөмж:

- Цаашид ЕБС төгсөгч нэмэгдэх тул хөтөлбөрийн олон жилийн туршлага, сургуулийн нэр хүндэд үндэслэн хөтөлбөрийн давуу талыг хөгжүүлэн элсэлтийг нэмэгдүүлэх боломжийг судалж, ашиглах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны хөгжил үйлчилгээний алба нь жил бүр оюутны үйлчилгээний төлөвлөгөө гаргаж ажилладаг. Түүнчлэн сургалтын алба, зөвлөх багш, анги удирдсан багш, оюутны байрны багш, эрхлэгч, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв, их эмч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.
- Бие хүний төлөвшил, харилцаа, эрүүл мэнд, хотын соёл, нийгмийн оролцоо, оюутны хөгжил, эдийн засаг, бизнес, гэмт хэрэг болон гамшгаас сэргийлэх чиглэлийн сургалтууд тогтмол зохион байгуулагддаг ба онлайн хэлбэрээр сургалтад оролцоогүй оюутнууд ч үзэх боломжтой байна. Зөвлөн туслах үйл ажиллагааны баялаг туршлагатай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Зайн сургалтаар оюутны хандсан тоо, нэвтэрсэн хугацаа тооцогддог суралцах явцад хяналт тавьж зөвлөн туслах боломжтой.
- 2020 оны 3-р сараас эхлэн үүрэн холбооны 3 компанитай гэрээ байгуулж UNIMIS-д бүртгэлтэй оюутны дата хэрэглээг үнэгүй болгосон байна.

Зөвлөмж:

- Оюутныг хөгжүүлэх арга хэмжээ төсөв санхүүгийн хүндрэлтэй тулгардаг. Сургуулийн зүгээс дээрх анхаарах асуудалд дэмжлэг үзүүлж төсвийн төлөвлөлтөд тусгах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- БУХС-ийн Алтан гадас, My club, Миний ном зэрэг клубүүд үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ ШУТИС-ийн хүрээний сайн дурын 16, мэргэжлийн 23 клубийн үйл ажиллагаанд оролцох боломжтой.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бодлогын баримт бичиг хөтөлбөрүүдийг батлан гаргасан. Оюутны хөдөлмөр эрхлэлт хариуцсан орон тооны мэргэжилтэн ажилладаг.
- Жил бүр “Ажил олгогчдын нэгдсэн өдөрлөг зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны олон нийтийн оролцоо, спорт, урлагийн амжилтыг сургуулийн зүгээс дэмжин урамшуулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутны олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны төсөв, оюутны оролцоо сүүлийн жилүүдэд буурсан.

Зөвлөмж:

- Сургуулийн зүгээс дээрх анхаарах асуудалд дэмжлэг үзүүлж төсвийн төлөвлөлтөд тусгахыг зөвлөмж болгов.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний тайлан, бусад судалгааг үзэхэд тайлант хугацаанд шилжиж явсан оюутны олонх бүрэлдэхүүн сургууль дотроо шилжсэн болон гадаадад суралцах шалтгаанаар өргөдөл гаргасан байна. Шилжин ирсэн оюутны тоо 23.
- ШУТИС-ийн ректорын 2016 оны А/188 тушаалаар бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журамд өөрчлөлт оруулснаар ШУТИС-д шилжин суралцсан бол Европын кредит хөрвүүлэх системийн 1.8 гэсэн шилжүүлэх коэффициентийг ашиглан хөрвүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн ректорын 2014 оны А/64 тоот тушаалын дагуу дипломын төсөл, ажил болон төгсөлтийн шалгалтыг “С” ба түүнээс дээш дүнтэй хамгаалсан тохиолдолд төгсөгчид тодорхой мэргэжлээр бакалаврын зэрэг бүхий диплом олгодог байна. Төгсөлтийн баримт бичигт мэргэшил, суралцсан хичээлүүдийн үнэлгээ, дипломын гүйцэтгэл зэргийг тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- БСШУ-ны сайдын 2010 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 2.3.2 “Нийт багш нарын 75-аас доошгүй хувь нь үндсэн багш байна.” гэсэн шаардлагыг хангасан байна.
- Хөтөлбөрт хамрагдах багш нарын 62.5% 10-аас дээш жилийн ажлын туршлагатай, 50% нь докторын зэрэгтэй байна.
- Хөтөлбөр хамрагддаг салбар төдийгүй бусад салбарын багш нар тухайн мэргэжлийн хичээлээ ордог.
- Төрийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд судлагдах мэргэжлийн суурь, мэргэшүүлэх, сонгон судлах нийт 18 хичээл тус бүрээр багшийн судалгааг гаргуулж дүгнэхэд бүгд холбогдох мэргэжлийн байсан ба үндсэн багш байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн тогтолцоог сургуулийн бодлогоор тасралтгүй, тогтвортой дэмжих зорилго бүхий багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна.
- Хөтөлбөрийг 2019 онд шинэчлэн баталж 2030 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж гаргажээ. Хөтөлбөр нь багшийн сургахуйн ур чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, багшийн хувь хүний хөгжлийг дэмжих, санхүү-нийгмийн түншлэлийг өргөжүүлэх гэсэн 4 зорилтын хүрээнд төлөвлөн ажиллаж байна.
- Тайлант хугацаанд мэргэжил, ур чадвар дээшлүүлэх сургалтад дотоод ба гадаадад 69 (давхардсан тоо) багш хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2019.05.08-ны А/113 тоот тушаалаар ШУТИС-ийн багш, ажилтны гүйцэтгэлийг үнэлж урамшуулах журам батласан ба үүнд эрдэм шинжилгээ, инновацын чиглэлд урамшууллыг тусгайлан тооцохоор тусгажээ.
- ШУТИС-ийн хөгжлийн стратегийн замын зураглал 2012-2021 бодлогын баримт бичигт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ач холбогдлыг үнэлэн стратеги тодорхойлсон байна.
- 2018 онд эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам боловсруулж баталсан.
- 6 төсөл болон гэрээт ажлын үр дүнд хөтөлбөрт сайжруулалт хийсэн байна.
- Тайлант хугацаанд нийтлүүлсэн бүтээлийн тоо 42, сүүлийн 5 жилд тус хөтөлбөрийн багш нар 16 бүтээлд зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хүрээг зохицуулах бодлогын баримт бичиг шинэчлэгдэн сайжирч баталсан боловч төсөв нь буурах хандлагатай байна.

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээ судалгааны төсөвлөлтийг сайжруулах замаар олон улсын түвшний судлаач багш нарыг төрүүлэх.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- 2019.05.08-ны А/113 тоот тушаалаар ШУТИС-ийн багш, ажилтны гүйцэтгэлийг үнэлж урамшуулах журам баталсан.

- Багш нарын ажлын үр дүнг хичээлийн жилийн эцэс төдийгүй улирлаар үнэлдэг. Шагнал, урамшууллын журамтай. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлт урамшууллыг тусгайлан тооцдог.
- Өөрийн үнэлгээг багш эхэлж гаргана, салбарын удирдлага, багш, оюутны санал нэмэгдэж үр дүнг тооцдог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дээрээс чиглэлтэй биш өөрийн үнэлгээнд тулгуурласан урамшууллын системтэй, өөрийн үнэлгээг хөндлөнгийн 3 үнэлгээгээр баталгаажуулдаг.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- БУХС-ийн захирлын -2018.11.20-ны А102 тушаалаар “Чанарын менемент” тогтолцоог нэвтрүүлэх, дэмжих баг баталсан.
- 2020.01.20-ны А16 тоот тушаалаар Чанарын менежментийн тогтолцооны гарын авлага баталсан.
- 2019.03.22-ны А70 тоот тушаалаар ШУТИС-ийн Чанарын бодлого зорилт, зорилтод хүрэх төлөвлөгөө баталсан.
- ISO9001:2015-ыг нэвтрүүлэх бэлтгэл хангасан ба 2020 оны 2 сараас нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байсан ч хорио цээрийн дэглэм тогтсонтой холбогдон түр хойшилсон байна.
- Чанарын баталгаажуулалтын тодорхой механизм, зохицуулалтын журмуудыг гаргаж ахиц дэвшил, үр дүнтэй ажилласан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Чанарын стандартуудыг үнэлэх арга зүйг гаргах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төрийн удирдлагын чиглэлээр суралцаж докторын зэрэг хамгаалсан 2, мастер түвшинд суралцаж хамгаалсан 36 хүн байна. Ажил олгогчдын төлөөлөл 11 хүнтэй онлайн уулзалт хийж ярилцахад хөтөлбөрөөр суралцаж төгсөгчийн мэдлэг, ур чадварт сэтгэл хангалуун байсан болно.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Ажил олгогчид сургалтын явцад оюутныг төрийн байгууллагад мэргэжлийн дадлага хийлгэж байх нь чухал байна гэсэн зөвлөмж дэвшүүлсэн.

Зөвлөмж:

- Хөтөлбөр нь CDIO арга зүйгээр боловсруулагдсан нь ур чадвар олгоход түлхүү анхаардаг тул оюутны дадлагын ажилд онцгой анхаарал хандуулах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Төрийн удирдлага хөтөлбөр нь хоёр дахь удаагаа магадлан итгэмжлүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Олон улсын нэр хүндтэй сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, туршлага судлах

ДҮГНЭЛТ

ШУТИС-ийн Төрийн удирдлага хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн “Төрийн удирдлага” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Б.Эрдэнэсүрэн

Шинжээчийн багийн гишүүн: Н.Бурмаа

Шинжээчийн багийн гишүүн: Г.Энхбаяр

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Төрийн удирдлага
Хөтөлбөрийн индекс	D041303
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Бусад улс орны их дээд сургуулийн Төрийн удирдлага хөтөлбөрийн туршлагаас суралцах, харьцуулсан судалгаа хийж хэвших. Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой үйл ажилагааг аль болох олон шат дамжлагагүй уян хатан болгох.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Англи болон бусад гадаад хэл дээр хэвлэгдсэн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> Сургуулийн гадаад орчинг илүү үзэмжтэй болгож, ойжуулах, цэцэрлэгжүүлэх асуудалд анхаарах. Сурах бичгийн эрэлт, хэрэгцээг судлах замаар тоо, ширхгийг нь оновчтой тогтоох замаар хүртээмжийг сайжруулах.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн удирдлага бие дааж шийдвэрлэх, үйл ажиллагааг ШУТИС-ийн бодлогын түвшинд дэмжих. Бусад их дээд сургуультай хамтран хөтөлбөрийн чанарыг сайжруулахад харилцан туршлагаа солилцож хэвших
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн олон жилийн туршлага, сургуулийн нэр хүндэд үндэслэн хөтөлбөрийн давуу талыг хөгжүүлэн элсэлтийг нэмэгдүүлэх боломжийг судалж, ашиглах. Оюутны олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны төсвийг сургуулийн төсвийн төлөвлөлтөд тусгах.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Эрдэм шинжилгээ судалгааны төсөвлөлтийг сайжруулах замаар олон улсын түвшний судлаач багш нарыг бэлтгэх.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөр нь CDIO арга зүйгээр боловсруулагдсан нь ур чадвар олгоход түлхүү анхаардаг тул оюутны дадлагын ажилд онцгой анхаарал хандуулах. Олон улсын нэр хүндтэй сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, туршлага судлах.
ШААРДЛАГА	
Шалгуур 4.3	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн төлөвлөгөөг хөтөлбөрийн түвшинд зардлын зүйл ангиар нарийвчлан төлөвлөж, төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан шинжилгээ хийж байх. Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээ хийж занших.
Шалгуур 4.4	<ul style="list-style-type: none"> Тус хөтөлбөрөөр суралцагч оюутан, төгсөгч нарын оролцоотойгоор хөтөлбөрөө сурталчлах

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл
1	Ж.Болдбаатар	Зөвлөх профессор ШУ-ны Гавьяат зүтгэлтэн, Академич, Доктор (Sc.D), профессор	D.PU701 Судалгааны арга зүй I II III
2	Г.Батхүрэл	БАТС-ийн Профессор МУ-ын Гавьяат эдийн засагч, Доктор (Sc.D), профессор	D.PU701 Төрийн захиргааны менежмент -3кр /сонгон/
2	Х.Пүрэвдавга	БАТС-ийн профессор МУ-ын Гавьяат багш, Доктор (Ph.D), профессор	D.PU701 Салбар хоорондын менежмент -3кр /заавал/
3	Д.Биндиряа	БАТС-ийн Бизнесийн удирдлага тэнхимийн эрхлэгч Доктор (Ph.D)	D.PA704 Нийтийн салбарт хувийн хэвшлийн түншлэл -3кр /сонгон/
4	Т.Ууганбаяр	БАТС-ийн дэд профессор, Доктор (Ph.D)	D.PU704 Нийтийн салбарын бодлогын шинжилгээ -3кр /заавал/
5	Я.Төгөлдөр	Нийгмийн Ухааны Салбарын эрхлэгч Доктор (Ph.D), дэд профессор	D.PU700 Орчин үеийн нийтийн удирдлага -3кр /заавал/
6	Б.Долгор	Хөтөлбөрийн профессор Доктор (Ph.D), дэд профессор	В.SS231 Нийтийн удирдлагын үндэс - 3кр /заавал/
			В.SS340* Нийтийн салбарын манлайлал -3кр /заавал/
7	Д.Одмаа	Хөтөлбөрийн дэд профессор Доктор (Ph.D), дэд профессор	В.SS335 Албан хэрэг хөтлөлт -3кр /заавал/
8	Д.Цогзолмаа	Ахлах багш Доктор (Ph.D), дэд профессор	S.SS113 Сэтгэл судлалын үндэс -3кр /сонгон/
9	Ж.Нямаа	Ахлах багш Доктор (Ph.D)	S.SS113 Сэтгэл судлалын үндэс -3кр /сонгон/
10	А.Болормаа	Ахлах багш Магистр (МА)	В.SS234 Төрийн алба, ёс зүй -3кр /заавал/
			В.SS333 Нутгийн удирдлага -3кр /заавал/
			В.SS336 Төрийн бодлого судлал -3кр /заавал/
			В.SS338* Улсын салбарын удирдлага -3кр /заавал/
			В.SS339 Хяналт шинжилгээ, үнэлгээ -3кр /заавал/
11	А.Оюунгэрэл	Ахлах багш Магистр (МА)	В.SS238 Гэрээний эрх зүй -3кр /сонгон/
			В.SS332 Захиргааны эрх зүй -3кр /заавал/
			В.SS337 Захиргааны процесс -3кр /заавал/
12	Т.Нямдулам	Ахлах багш Магистр (МА)	В.SS131 Төр, эрх зүйн онол -3кр /заавал/
			В.SS232 Иргэний эрх зүй -3кр /заавал/
			В.SS334 Хөдөлмөрийн эрх зүй -3кр /сонгон/

			В.SS342 Засгийн газрын худалдан авах ажиллагаа -3кр /сонгон/
1 3	Г.Солонго	Ахлах багш Магистр (МА)	В.SS236 Төр, хувийн хэвшлийн туншлэл -3кр /заавал/
			В.SS239 Үндсэн хуулийн эрх зүй -3кр /сонгон/

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	Цахим хаяг
1	М.Хулан	ТУ-IV курс	УБ хотоос	91170705	hulanivy0312@gmail.com
2	А.Янжинлхам	ТУ-IV курс	Дотуур байр	89237771	ynjaa.0728@gmail.com
3	Б.Эрдэнэзаяа	ТУ-IV курс	Налайх	80606127	zayab7411@gmail.com
4	Х.Халиун	ТУ-IV курс	УБ хотоос	88940148	haliukhaliuna123@gmail.com
5	Б.Дөлгөөн	ТУ-IV курс	Хөдөө орон нутгаас	89025229	dulguunb5229@gmail.com
6	Э.Дашцэрэн	ТУ-IV курс	Хөдөө орон нутгаас	85550698	Dashkadashka890@gmail.com
7.	Ц.Цэрэндагва	ТУ-IV курс	Голч үнэлгээ	88610118	Tserendagvatsengel@gmail.com
8	Ц.Бямбацэцэг	ТУ-IV курс	Нийгмийн идэвх	95491930	ts.byambatsetseg0627@gmail.com
9	А.Мөнх-Итгэл	ТУ-III курс	Нийгмийн идэвх	95647389	Itgelundram794@gmail.com
10	Б.Золжаргал	ТУ-III курс	Нийгмийн идэвхи	99947113	Zol9395@gmail.com
11	Г.Оюунцэнгэл	ТУ-III курс	Хөдөө орон нутгаас	94115768	oyuntsengeldolgorhand@gmail.com
12	Ж.Ганчимэг	ТУ-III курс	Оюутны байранд	80208096	ganchimegbatdorj89@gmail.com
13	Б.Наранболор	ТУ-III курс	УБ хотоос	95861979	naranbolor8686@gmail.com
14	Б.Баттулга	ТУ-III курс	УБ хотоос	86209091 95268484	battulga2000019@gmail.com
15	Ч.Туул	ТУ-II курс	Голч үнэлгээ	80405014	chuluunbattuul934@gmail.com
16	Б.Хонгорзул	ТУ-II курс	УБ хотоос	80520200	Hongorzulbatbayar738@gmail.com
17	Т.Хонгорзул	ТУ-II курс	Нийгмийн идэвх	95149449	hongorzultumurochir@gmail.com
18	Ц.Отгон-Эрдэнэ	ТУ-II курс	Дорнод	99575012	otgonerdenetseren@gmail.com
19	А.Хулан	ТУ-II курс	Нийгмийн идэвх	95204515	akhulan0312@gmail.com

20	Б.Наранбаатар	ТУ-II курс	УБ хотоос	99869001	bnaraa310@gmail.com
----	---------------	------------	-----------	----------	---------------------

III. Ажил олгогчдын нэрс

№	Оюутны нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Ж.Билэгсайхан	“УБ хотын Хөгжлийн корпораци” ХХК захирал	88050098	mendsaikhanubd@gmail.com
2	П.Ганчимэг	“Ice-mark” ХХК гүйцэтгэх захирал	80116051	Bayarmagnai9812@gmail.com
3	Ж.Цолмон	ЦЕГ-Дотоодын цэргийн 805-р ангийн хүний нөөц, соёл хүмүүжил эрхэлсэн орлогч	99731771	Tulgaaganbat@gmail.com
4	Б.Мөнхболд	“CVS Mongolia” ХХК үйл ажиллагаа эрхэлсэн захирал	88884436	Umpomn7@gmail.com
5	Г.Мөнхчимэг	Витафит ХХК хүний нөөцийн ахлах мэргэжилтэн	99045578	Munkhchimeg8818@gmail.com
6	С.Очир	СХД, 6-р хорооны Засаг дарга		buted.smile@gmail.com
7	И.Энхцэцэг	ҮСГ-ын хүний нөөцийн ахлах мэргэжилтэн	91915034	Eegii91915034@gmail.com
8	Ж.Тамжид	Нийслэлийн ШУҮИГ Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга	99054743	Tamjid.sidia@gmail.com
9	Б.Алтансүх	Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	88004199	nbuyntogtoh@gmail.com
10	Л.Даваахүү	Сайн компьютерс ХХК хүний нөөцийн менежер	88106030	Hr@esain.mn
11	М.Бат-Эрдэнэ	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	80 017771	baagii0717@gmail.com

IV. Төгсөгчдийн нэрс

№	Оюутны нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	М.Биндэръяа	2015	ОУБ-ын байгууллагад сайн дурын ажилтан	94942293	Binderiya.joy@gmail.com
2	С.Цэцэгсүрэн	2015	Монгол банк, Эрдэнэсийн сангийн мэргэжилтэн	99951299	Tseegiis0825@gmail.com
3	Г.Тулга	2015	ЦЕГ-Дотоодын цэргийн штабын Хүний нөөц хариуцсан ахлах офицер	99731771	Tulgaaganbat@gmail.com
4	Эрдэнэцэцэг	2015	ЦЕГ-ын Хүний нөөц архивын албаны мэргэжилтэн	88053926	jargalsaikhanerdenetsetseg257@gmail.com

5	Б.Мэндсайхан	2016	УБ хотын Хөгжлийн корпораци ХХК дэд захирал	99132476	mendsaikhanubd@gmail.com
6	Э.Бүтэд-Эрдэнэ	2016	СХД, 6-р хороо. Зохион байгуулагч	95333305	buted.smile@gmail.com
7	Э.Сэрсэндэмид	2016	БЗД, ХХҮХэлтэс, халамжийн мэргэжилтэн	89488968	Sersen9497@gmail.com
8	Х.Айбол	2017	Бизнес эрхлэгч	95011117	Aibolboken@gmail.com
9	Б.Жаргалмаа	2018	Дархан Уул аймаг, ШШГАлба нярав	95116222	Baatarjargalmaa2@gmail.com
10	Б.Цэрэндулам	2018	Хөтөл, Цемент үйлдвэр ХН, бичиг хэргийн ажилтан	95819884	Duya1020@gmail.com
11	Ү.Загарзүсэм	2018	БГД, Улсын бүртгэлийн хэлтэс, улсын бүртгэгч	99888418	uitumenz0221@gmail.com
12	Б.Долгор	2018	Нийслэлийн ШУҮИГ, Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлсэн мэргэжилтэн	95005482	dolgor1617@gmail.com
13	Л.Баярмагнай	2019	ТЭСО ХХК-д Хүний нөөцийн менежер	88032437	Bayarmagnai9812@gmail.com
14	Э.Энхбилэг	2019	Интерактив ХХК борлуулалт, маркетингийн менежер	80100906	Enhbileg888@gmail.com
15	Э.Энхжин	2019	АПУ трейдинг ЗХНАлбаны ажилтан	99361917	enhjin99eegii@gmail.com
16	Н.Буянтогтох	2019	ЗГХА мал эмнэлэгийн ерөнхий газар Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	99037751	nbuyntogtoh@gmail.com

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/

	БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	
13361 ш/х-49/313, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, Их тойруу, ШУТИС-ийн V байр, Утас/Факс: (976-11) 45 81 51, И-мэйл: secretary.sbh@must.edu.mn, Вэбсайт: www.sbh.edu.mn	
Ард. 06-08 № 330	
танай _____-ны № _____-т	
Санал хүргүүлэх тухай	
<p>Тус сургуулийн "Төрийн удирдлага" хөтөлбөрийн 2 дахь удаагийн магадлан итгэмжлэлд ажилласан Шинжээчдийн багийн санал зөвлөмжтэй танилцлаа. Санал, зөвлөмжийг цаашдын ажилд тусган ажиллах болно.</p> <p>Хамтран ажилласанд баярлалаа.</p>	
ЗАХИРАЛ	 А.ЭНХБАТ

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2020.06.12
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилнэ	5 жил

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) 2020.06.16
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилнэ	5 жил

Зөвлөмж /Recommendations/